

**ИРГЭД ХАРИЛЦАН ЗОРЧИХ НӨХЦЛИЙН ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ
КУБА УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН
ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн Газар, Бүгд Найрамдах Куба Улсын Засгийн Газар /цаашид “Хэлэлцэн тохирогч Талууд” гэнэ/,

Хоёр орны найрсаг харилцааг цаашид улам өргөтгөн хөгжүүлэх хүсэл эрмэлзлийг удирдлага болгон,

Иргэд харилцан зорчих нөхцлийг хялбарчлах зорилгоор,

Дараах зүйлийг хэлэлцэн тохиров.

Нэгдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрт хавсаргасан Хэлэлцэн тохирогч Талуудын хүчин төгөлдөр үндэсний гадаад паспорт эзэмшигч этгээдүүд нөгөө талын нутаг дэвсгэрт гуч /30/ хоногийн хугацаанд визгүйгээр орох, гарах, дамжин өнгөрөх, оршин сууж болно.

Хоёрдугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч Талууд аль нэг Талын нутаг дэвсгэрт байрлаж буй нөгөө Талын дипломат болон консулын төлөөлөгчийн газарт ажиллаж буй хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигчид, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд томилолтынхоо хугацаанд визгүй зорчих эрх олгоно.

2. Хэлэлцэн тохирогч Талууд аль нэг Талын нутаг дэвсгэрт байгаа Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт ажиллаж буй нөгөө Талын хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигчид, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд энэхүү зүйлийн 1-ийн заалтыг нэгэн адил хамааруулна.

Гуравдугаар зүйл

1. Энэхүү Хэлэлцээрийн хоёрдугаар зүйлийн 1, 2-т зааснаас бусад тохиолдолд аль нэг Талын хүчин төгөлдөр үндэсний гадаад паспорт эзэмшигч нь нөгөө Талын нутаг дэвсгэрт гуч /30/ хоногоос дээш хугацаагаар зорчих бол виз авна.

2. Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллага энэхүү зүйлийн 1-д заасан визийг хураамжгүй олгоно.

Дөрөвдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч Талуудын аль нэг Талын иргэд нөгөө талын нутаг дэвсгэрт зорчихдоо түүний олон улсын хилийн нээлттэй боомтоор нэвтэрнэ.

Тавдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллага тааламжгүй этгээд /persona non grata/ гэж үзсэн нөгөө Талын этгээдийг өөрийн улсын нутаг дэвсгэрт оруулахаас татгалзах буюу оршин суух хугацааг нь богиносгох эрх эдэлнэ.

Зургадугаар зүйл

Хэлэлцэн тохирогч аль нэг Тал үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалах зорилгоор энэхүү Хэлэлцээрийг бүхэлд буюу түүний зарим заалтын үйлчлэлийг түр зогсоож болох ба энэ тухайгаа болон уг Хэлэлцээрийн үйлчлэлийг дахин сэргээх тухай Хэлэлцэн тохирогч нөгөө Талд дипломат шугамаар нэн даруй мэдэгдэнэ.

Долдугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү Хэлэлцээрийн нэгдүгээр зүйлд заасан хүчин төгөлдөр үндэсний гадаад паспортын загварыг дипломат шугамаар солилцоно.

2. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал хүчин төгөлдөр үндэсний гадаад паспортад өөрчлөлт оруулах тухайгаа нөгөө Талд мэдэгдэж, хэрэглэж эхлэхээс гуч /30/ хоногийн өмнө шинэ паспортын загварыг дипломат шугамаар хүргүүлнэ.

Наймдугаар зүйл

1. Энэхүү Хэлэлцээр нь түүнд гарын үсэг зурснаас хойш 30 дахь өдрөөс хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү Хэлэлцээрийг тодорхой хугацаагүй байгуулсан бөгөөд Хэлэлцэн тохирогч аль нэг Тал түүнийг цуцлах тухайгаа нөгөө Талдаа бичгээр мэдэгдсэн өдрөөс хойш 90 хоногийн дараа уг Хэлэлцээр хүчингүй болно.

3. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал энэхүү Хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах бол Хэлэлцэн тохирогч нөгөө Талтай тохиролцож нот солилцох замаар хийнэ.

Есдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Куба Улсын Засгийн газар хоорондын 1967 оны хоёрдугаар сарын 1, 1967 оны хоёрдугаар сарын 3-нд Гавана хотноо солилцсон ноот бичиг хүчингүй болно.

Энэхүү Хэлэлцээрийг Улаанбаатар хотноо 2001 оны 10 дугаар сарын 08-ны өдөр монгол, испани хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг

**БҮГД НАЙРАМДАХ КУБА УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

Гарын үсэг

ХАВСРАЛТ

Энэхүү Хэлэлцээрийн нэгдүгээр зүйлд заасан паспорт нь:

Монгол Улсын хувьд:

- дипломат паспорт
- албан паспорт
- энгийн паспорт
- Монгол Улсад буцах үнэмлэх

Бүгд Найрамдах Куба Улсын хувьд:

- дипломат паспорт
- албан паспорт
- албан ажлын паспорт
- далайчны паспорт